



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 10 өдөр

Дугаар Б/12

Мөрөн сум

**Цэвэр усны Эх үүсвэрийн барилга байгууламжийг
хүлээн авах комисс томилох тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "ХАНГАЙН ИЛЧ ДУЛААН" ХХК-аас Мөрөн сумын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгөх Цэвэр усны Эх үүсвэрийн барилга байгууламжийг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:	Э.Балчиндорж	Цагаан толгой багийн Засаг дарга
Гишүүд:	Г.Хишигбаатар	Хууль эрх зүйн мэргэжилтэн
	Ш.Баасандорж	Байгаль орчны хяналтын улсын байцаагч
	Н.Пүрэвцэрэн	Шуурхай үйлчилгээ засварын монтёр
	А.Энхтөр	Аж ахуйн нярав

2. "ХАНГАЙН ИЛЧ ДУЛААН" ХХК-ийн барьж, хүлээлгэн өгч байгаа Цэвэр усны Эх үүсвэрийн барилга байгууламжийг хүлээн авахдаа барилга байгууламжийн бүрэн бүтэн байдал, техник тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг сайтар шалгаж, нэг бүрчлэн акт үйлдэн хүлээн авахыг комиссын дарга (Э.Балчиндорж)-д үүрэг болгосугай.

3. Цэвэр усны Эх үүсвэрийн барилга байгууламжийг үндсэн хөрөнгөнд бүртгэж авч ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д даалгасугай

ДАРГА



Н.НАМЖИЛНОРОВ